# УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН С.ЛХАГВАСҮРЭН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | | Өөрийн үнэлгээ | Менежерийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ЗОРИЛТ 1. "УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСАХ АНАГААХ УХААНЫ ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙГ УДИРДЛАГА АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАН, ХОЛБОГДОХ ТУШААЛ ЗААВРЫГ МӨРДҮҮЛЭН АЖИЛЛАЖ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Уламжлалт, сэргээн засах, ахмад настаны төлөвлөгөөний загвар боловсруулан батлуулж ЭМБ-руу хүргүүлэх | Төлөвлөгөө боловсруулан батлуулан, ЭМБ-руу хүргүүлэх | Төлөвлөгөө боловсруулан, хүргүүлсэн байна | 01 сард 2 зорилт бүхий 14 арга хэмжээтэй төлөвлөгөөний загвар батлуулан бүх эрүүл мэндийн байгууллагуудруу хүргүүлсэн | 100% | |
| 2 | Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн байгууллагуудыг уламжлалт, сэргээн засах, ахмад настаны тусламж үйлчилгээний төлөвлөөтэй ажиллуулан, хэрэгжилтэд хяналт тавих | Төлөвлөгөө хэрэгжүүлж байгаа ЭМБ-н тоо, хэрэгжилтийн хувь | ЭМБ-н тоо-5 Хэрэгжилт 70% | Уламжлалт, сэргээн засах, ахмад настаны төлөвлөгөөний загварыг нийт 5 эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 65%-тай байна. | 85% | |
| 4 | Арга хэмжээ №1.3. Эрүүл мэндийн байгууллагуудад ЭМС-ын А/378, А/502 тоот тушаалын дагуу Уламжлалт болон сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, шинэ арга технологи, эм, засал нэвтрүүлэх | Нэмэгдсэн нэр төрлийн тоо | 2 | Аймгийн нэгдсэн эмнэлэгт 4 ширхэг сеража ор тусламж үйлчилгээндээ нэвтрүүлэн нийт 95 хүн эмчилгээнд хамрагдсан байна.<br>Мөн HotPack дулаан эмчилгээний аппарадыг нэвтрүүлсэн бөгөөд 400 гаруй үе мөчний өвчлөлтэй хүнд хэрэглэсэн байна.<br>Ихтамир, Чулуут сумдад гарын доорх материал ашиглан сэргээн засах | 90% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | эмчилгээний туслах хэрэгсэл хийж ашиглаж байна.<br>Жишээ нь шагайн эрх, ундааны бөглөөгөөр танин мэдэхүйн тоглоом гэх мэт | | |
| 5 | Арга хэмжээ №1.4. Эрүүл мэндийн байгууллагуудад сувилахуйн албаны дарга, ахлах сувилагч нарыг ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллуулан, хяналт хийж, мэргэжил арга зүйгээр хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>Хяналт хийж зөвлөгөө өгсөн тоо | 91%<br>1 | ДЭМБ-ын Сувилахуйн тусламж үйлчилгээг 2021-2025 онд хөгжүүлэх стратегийн дагуу эрүүл мэндийн төвүүдийн ахлах сувилагчдад зориулан 6 зорилт, 23 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний загварыг боловсруулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилийн байдлаар 90,3 байна.<br>Нийт 11 эрүүл мэндийн байгууллагуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийсэн байна.<br>Үүнд сум-9, өрх-2 хяналт шалгалт хийгдэж, ажлын байран дээрх зөвлөмжийг өгсөн байна | 90% | |
| 6 | Арга хэмжээ №1.5. СӨЭМТ-үүдэд гэрийн сувилгааг /хэвтрийн өвчтөн, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрсөн эх, нярайн асаргаа сувилгаа/ чанар хүртээмжтэй үзүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг тооцох | Гэрийн сувилгаа үзүүлсэн хүнтий тоо | 1000 | ЭМС-ын 2017.01.26 ний өдрийн А/41 тоот тушаал, ЭМС-ын 2015.12.18-ны 497 тоот тушаал, сувилахуйн тусламж үйлчилгээний 5 шатлалыг хэрэгжүүлэх журмын дагуу 22 эрүүл мэндийн байгууллга 2025 оны хагас жилийн байдлаар 1524 хүнд гэрийн асаргаа, сувилгаа үзүүлэн ар гэр асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 100% | |
| 7 | Арга хэмжээ №1.6. Шинэ сувилагч сургалтын хөтөлбөрийг шинэчлэн, | Хөтөлбөрийг шинэчлэх, | А/95 шинэчлэх | Шинэ сувилагч, шинэ эх баригчийн сургалтын хөтөлбөрийг нэгтгэн | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажлын хэсгийг шинээр байгуулах | ажлын хэсэг байгуулах | | боловсруулахаар төлөвлөлт хийгдэж байна. | | |
| ЗОРИЛТ 2. "УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН ЗАСХЫН ЭМЧ, СУВИЛАГЧ, ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАН, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ, ИРГЭДЭД ЭМБ ОЛГОХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 8 | Арга хэмжээ №2.1. Уламжлалт, сэргээн засахын эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг ажлын байрны болон төгсөлтийн дараах урт болон богино хугацааны сургалтуудад тогтмол хамруулана /танхим, цахим/ | Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо, сургалтын тоо | Гүйцэтгэлээр | Хөдөлмөр заслыг хүн бүрт олон улсын хурал Архангай аймагт зохион байгуулагдсан ба гэмтэл, харвалтын дараах хөдөлмөр засал, хөгжлийн бэрхшээлтэй болон мэдрэл сульдалын хам шинжтэй хүүхэд, насанд хүрэгчдийн сэргээн засах тусламж үйлчилгээний эмнэлзүйн гардан 2 өдрийн сургалтад 52 эмч, мэргэжилтэн хамруулсан.<br>Бие бялдар сэргээн засахын нийгэмлэгээс зохион байгуулсан "Түгээмэл тохиолдох өвчний үеийн сэргээн засах тусламж үйлчилгээ" сэдэвт цахим сургалтад 11 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. | 100% | |
| 9 | Арга хэмжээ №2.2. Шинэ сувилагч сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хамрагдсан сувилагчийн тоо | - | 2024 оны 11 сарын 04-с 2025 оны 01 дүгээр сарын 26-ны хооронд Шинэ сувилагчын хөтөлбөрийг нэгдсэн эмнэлэг, сум өрхийн нийт 9 шинэ сувилагч хамрагдлаа.<br>Дараагийн ээлжийн хөтөлбөр эхлэх хугацаа болоогүй байна. | 100% | |
| 10 | Арга хэмжээ №2.3. Уламжлалт, сэргээн засахын мэргэжилтнүүдийн боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг гэх мэт судалгааг шинэчлэх | Судалгааг шинэчлэх | Судалгааг шинэчлэсэн байна | Судалгааг энэ оны 5 сард шинэчлэсэн бөгөөд Архангай аймгийн эрүүл мэндийн салбарт 45 уламжлалт, сэргээн засахын эмч, мэргэжилтнүүд ажиллаж байна.<br>Нарын мэргэжил эзэмшин их эмч 2, эрдмийн зэрэгтэй 2, мэргэжлийн зэрэгтэй 5 мэргэжилтэн байна. | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | Арга хэмжээ №2.4. Уламжлалт анагаах ухааны дэмжих баг байгуулах | Дэмжих багтай болох | Байгуулсан байна | Эрүүл мэндийн газрын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/36 тоот тушаалаар "Уламжлалт ангаах ухааны нөлөөллийн баг" буюу ЭМГ, НЭ, сум, өрх, ХХЭ-н төлөөлөлүүдийг хамарсан 10 хүний бүрэлдэхүүнтэй баг байгуулсан бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах шатандаа явж байна | 100% | |
| 12 | Арга хэмжээ №2.5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээнд хүн амд уламжлалт ёс заншил, цаг улирал, идээ ундаа, явдал мөртэй холбогдуулан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дадал, мэдлэг олгох сургалт, сурталчилгааг тогтмол хийх | Хийгдсэн сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо | Гүйцэтгэлээр | Эрүүл мэндийн байгууллагуудын Уламжлалт, сэргээн засах, ахмад настаны тусламж үйлчилгээний төлөвлөгөөний дагуу уламжлалт ёс заншил, цаг улирал, идээ ундаа, явдал мөртэй холбогдуулан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дадал, мэдлэг олгох сургалтын 4 удаа 70 гаруй хүнд хийсэн байна. Мөн байгууллагууд пэйж хаягаараа дамжуулан уламжлалт идээ ундаатай холбоотой сурталчилгааны шторк, рекламуудыг тогтмол явуулж байна. | 70% | |
| ЗОРИЛТ 3. БАЙГУУЛЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ | | | | | | |
| 13 | Арга хэмжээ 3.1. Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль дүрэм журам, холбогдох зааврyудыг мөрдөж ажиллах | Байгууллага ас гаргасан хууль, дүрэм, журманд захирагдана | Гүйцэтгэлээр | Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль дүрэм журам, холбогдох зааврyудыг мөрдөн ажиллаж байна. | 100% | |
| 14 | Арга хэмжээ 3.2. Байгууллагын удирдлага болон мэргэжилтэн, ажилчдаас хүлээлгэн өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрт нь шуурхай гүйцэтгэх | Байгууллага ас гаргасан хууль, дүрэм, журманд захирагдана | Гүйцэтгэлээр | Байгууллагын улирдлага болон хэлтсийн даргын даатган өгсөн хугацаатай албан бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлан, хариуг хугацаанд нь тайлагнаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15 | Арга хэмжээ 3.3. Хамт олон, олон нийтийг хамарсан ажилд идэвхтэй оролцох, өглөөний шуурхай яриа, сургалтанд тасалдалгүй оролцох | Байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журманд захирагдана | Гүйцэтгэлээр | Архангай аймагт эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 100 жилд зориулсан спортын 6 төрөлдт тэмцээний 3 төрөлд нь оролцон 3х3 төрөлд 2-р байр эзэлсэн. Мөн бүх нийтийн цэвэрлэгээ, мод тарих, шуурхай ярианд тогтмол оролцсон байна. | 100% | |
| 16 | Арга хэмжээ 3.4. Хариуцсан ажлын чиглэлээр эрхзүйн баримт бичгийг хувийн хэргийн хавтасыг нээж, баяжуулах | Баримт бичгийн хавтас нээсэн эсэх | Гүйцэтгэлээр | Өөрийн хувийн хавтсанд нэг удаа баяжуулалт хийсэн. Мөн шинэ сувилагч хөтөлбөрийн хавтас, Уламжлалт анагаах ухааны нөлөөллийн багийн хавтас нээн баяжуулж байна. | 100% | |

ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт | Өөрийн үнэлгээ | Менежерийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ | | | | | |
| 1 | Үүрэг даалгавар 2.1. Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд багц цагын сургалт зохион байгуулах | Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс | Улсын гуравдугаар төв эмнэлгийн сувилахуйн албатай хамтран "Үйлчилгээний стандартад сувилагчийн манлайлал" сэдэвт онол, гардан үйлдлийн 2 багц цагийн сургалтыг 01 дүгээр сарын 30-31 өдрүүдэд зохион байгуулсан ба сургалтад бүх эрүүл мэндийн байгууллагын 214 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан. | 100% | |
| 2 | Үүрэг даалгавар 2.2. Өөрийн орон нутагт олон улсын хурал зохион байгуулах | Эрүүл мэндийн газрын дарга | "Хөдөлмөр заслыг хүн бүрт" олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 05 дугаар сарын 30-31 өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулсан ба Хятад, | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Япон, Шанхай, Монголын 150 гаруй эмч, мэргэжилтнүүдийг хамруулж туршлага солилцлоо. | | |
| 3 | Үүрэг даалгавар 2.3. Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1 дэх зорилтын биелүүлэх | Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс | Монголын чанарын холбоотой хамтран "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал" сэдэвт сургалтыг 06 дугаар сарын 06-07 хооронд зохион байгуулсан ба бүх эрүүл мэндийн байгууллагын чанарын багийн төлөөлөл болох 74 эмч, мэргэжилтнийг хамруулж багаар чадвахжуулсан. | 100% | |
| 4 | Үүрэг даалгавар 2.4. Зуун жилийн номны эх бэлдэх | Удирдлага мэдээллийн хэлтэс | Архангай аймагт эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан номны эх бэлдсэн бөгөөд 2019 оны онцлох үйл явдлуудыг түүвэрлэн авч бэлтгэсэн | 100% | |
| 5 | Үүрэг даалгавар 2.5. Шилдэг эмч, мэргэжилтэн шалгуулах | Удирдлага мэдээллийн хэлтэс | Засаг даргын захирамжийн дагуу бүх эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн 100 гаруй эмч, мэргэжилтний материалыг ажлын хэсгийн хамт үнэлж шилдэг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, бага эмч, НЭМА-г шалгаруулав. | 100% | |

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | Өөрийн үнэлгээ | Менежерийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛТ 1. "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Байгууллагаас болон дээд байгууллагуудаас зохион байгуулж буй урт, богино хугацааны сургалтад хамрагдах | Гүйцэтгэлээр | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан тамхимын сургалтад 1 удаа , Шинжлэх ухаан иннивацийн төвийн төлөвлөгөөт сургалтад тогтмол хамрагдсан байна. Мөн ЭМЯ-с зохион байгуулсан "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн гамшгийн үзүүлэх сургалт"-д хамрагдсан. | 100% | |
| 2 | Арга хэмжээ 1.3. Эрүүл мэндийн удирдлагын магистрын чиглэлээр суралцах | Тийн | Глабол удирдагч дээд сургуулийн Эрүүл мэндийн менежментийн магисрантын хөтөлбөрийн хаврын элсэлтэд элсэн суралцаж байна. | 100% | |
| | | | | | 95 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

УЛАМЖЛАЛТ, СЭРГЭЭН
ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — С.ЛХАГВАСҮРЭН /................/

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА — Ө.МӨНХШҮР /......................./ 2025.06.30